



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	3 - 4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 - 12

1. *“Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2023.10.04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/* 5 - 11
2. *“Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2023.10.04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/* 12

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 10 дугаар сарын 05-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 57 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Бат-Эрдэнэ, Д.Өнөрболор;

Чөлөөтэй: Д.Батлут, Н.Ганибал, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Ч.Хүрэлбаатар, Б.Энхбаяр.

Нэг. “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2023.10.04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүүгийн хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, мөн газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Л.Өлзийбаяр, Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Ц.Нямбаяр, Монгол Улсын Шадар сайдын Ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Зөвшилцөх тухай асуудлыг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, М.Оюунчимэг, Ч.Ундрам нарын тавьсан асуултад Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян хариулж, тайлбар хийв.

Ц.Цэрэнпунцаг: “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2023.10.04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүүгийн хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, мөн газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Л.Өлзийбаяр, Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Ц.Нямбаяр, Монгол Улсын Шадар сайдын Ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Зөвшилцөх тухай асуудлыг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 22 минут үргэлжилж, 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр 10 цаг 19 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
9 цаг 57 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн гадаадад томилолттой ажиллаж байгаа. Д.Өнөрболор гишүүн орон нутагт ажиллаж байгаа юм байна. Томилолттой. Ц.Даваасүрэн гишүүн орон нутагт томилолттой гэж энэ дээр бичсэн байна. Би сая коридорт таарсан. Ирцдээ ирж орно уу гэж Ц.Даваасүрэн гишүүн айлтгал өргө дөө.

Байнгын хорооны гишүүдийн ирц 55.6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал.

Нэг. “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх.

Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр зөвшилцөхөөр хүргүүлсэн. Нэн яаралтай. Санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

Хоёр. “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх.

Мөн 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр зөвшилцөхөөр хүргүүлсэн. Яаралтай. Санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ гэсэн ийм хоёр асуудлыг хэлэлцэнэ.

Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг. “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төсөл

/Засгийн газар 2023.10.04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Нэг дэх асуудал. “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалттай машин нийлүүлэх төсөл”-

ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн

хэлэлцээрийн төслийн хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцээрийн төслийн талаарх төсөл санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан хийнэ.

Сангийн сайдын микрофоныг нээж өгнө үү.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газраас 2019 онд авсан 58 сая еврогийн зээлийн хөрөнгөөр онцгой байдлын байгууллагад агаараас аврах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төслийг хэрэгжүүлж байна.

Төслийн хүрээнд 4 нисдэг тэрэг худалдан авч, нисдэг тэрэгний дэд бүтцийг байгуулж, нисгэгч, инженерүүдийг сургалтад хамруулсан бөгөөд 2023 оны 9 дүгээр сарын байдлаар 85 удаагийн тусгай үүргийн нислэг үйлдэж, ослын улмаас бэртэж, гэмтсэн газраар тээвэрлэх боломжгүй нөхцөлд байсан 122 иргэний амь насыг аварч, анхан шатын тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлэн дараагийн шатын эмнэлгийн байгууллагад цаг алдалгүй хүлээлгэн өгсөн.

Түүнчлэн тусгай тоноглол бүхий 42 гал унтраах автомашиныг нийслэл болон орон нутгийн Онцгой байдлын ерөнхий газрын харьяа гал түймэр унтраах ангиудад хүлээлгэн өгч, онцгой байдлын байгууллагын албан хаагчдыг сургалтад хамруулан, 2235 удаагийн дуудлагаар үүрэг гүйцэтгэн, 853 хүний амь нас, аюулгүй байдлыг хангаж ажилласнаас гадна 216.8 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг эвдэрч

сүйдэхээс сэргийлэх үүрэг гүйцэтгэсэн болно.

Монгол Улсад оруулсан дээрх хувь нэмэр, нийгмийн үр өгөөжийг өндрөөр үнэлж Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч Эммануэль Макрон нь Монгол Улсад 2023 оны 5 дугаар сард хийсэн айлчлалын үеэр хоёр улсын Ерөнхийлөгч нарын хамтарсан тунхаглалд дээрх төслийг үргэлжлүүлж, төслийн хоёрдугаар үе шатыг эхлүүлэхээр тогтсон.

Төслийн хоёрдугаар үе шатын хүрээнд онцгой байдлын байгууллагын 12 нисгэгчийг чадавхжуулах, аврах ажиллагааны мэргэжилтэн, аврагч, эмч, сувилагч нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, нисдэг тэрэгний засвар, үйлчилгээ хийх инженерүүдийг бэлтгэх, холбогдох программ хангамж худалдан авах, гал түймэр, хөөсөөр унтраах автомашин, механик шатны автомашин, хөрс үүсгэгч бодис авч аюулт үзэгдэл гал түймэр унтраах үйл ажиллагааг хангах юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч Бүгд Найрамдах Франц Улсад 2023 оны 10 дугаар сард хийх төрийн айлчлалын үеэр төслийн хоёрдугаар үе шатыг хэрэгжүүлэх санхүүгийн хэлэлцээрт гарын үсэг зурахаар төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд жилийн 0.282 хувийн хүүтэй, 20 жилийн хугацаатай, 38 сая евротой тэнцэх хэмжээний нэн хөнгөлөлттэй зээл авах юм.

Дээрх төсөл нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 75.3-т заасан шаардлагыг хангаж байгаа бөгөөд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 7.3.20, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.11-д туссанаас гадна төсвийн төсөлд тусгагдсан гадаад

зээлийн хөрөнгийг авч ашиглах тохиолдолд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын үүргийн тухай төсвийн тусгай шаардлагыг бүрэн хангаж байгаа болно.

Иймд төслийн хоёрдугаар үе шатын хүрээнд хэрэгжүүлэх Агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл, гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийн санхүүгийн хэлэлцээрүүдийг хэлэлцэн дэмжиж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулья.

Сангийн сайд Болдын Жавхлан, Г.Ариунбуян Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал, Б.Сүх-Очир Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Л.Өлзийбаяр Онцгой байдлын ерөнхий газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, хурандаа, Ц.Нямбаяр Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа, Б.Мөнх-Оргил Монгол Улсын Шадар сайдын Ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны дарга, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүүгийн хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга.

Хэлэлцээрийн төслийн талаар асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Ч.Ундрам гишүүнээр тасаллаа.

Т.Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Онцгой байдлын ерөнхий газрын аврах ангид нэмэлт сургалт явуулах төслийн санхүүжилт гээд ийм төсөл орж ирсэн

байна. Үүнийг ерөнхийд нь дэмжиж байна.

Үнэхээр Монгол Улсад сүүлийн жилүүдэд газрын тос боловсруулах үйлдвэр, байгалийн хий дамжуулах хоолой гээд томоохон бүтээн байгуулалтын ажлууд явагдаж байна.

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангаас хийсэн судалгаагаар 2050 он гэхэд Монгол Улсын нийт хүн амын 78.0 хувь нь төвлөрсөн суурин газар амьдарна гэсэн тооцоо гарсан байж байна.

Тэгэхээр цаашдаа галын аюул, газар хөдлөлт гээд ийм эрсдэлүүд нэмэгдэх хандлагатай болж байгаа.

Тийм учраас онцгой байдлын тоног төхөөрөмж, техник, машин механизмыг сайжруулах, ялангуяа боловсон хүчнийг бэлтгэх, нисгэгч нарыг сургах гээд энэ ажлуудыг цаашдаа яаралтай хийгээд явах нь зүйтэй л гэсэн ийм бодолтой байна.

Хоёр дахь асуудал нь, Дорноговь аймагт хүүхэд алга болсон асуудал гарсан.

Цаашдаа бид Цагдаагийн ерөнхий газрыг ч гэсэн нисдэг тэрэгтэй болгох, ялангуяа хамгийн сүүлийн эрэн аврах аврагч нарыг бэлтгэх ч гэдэг юм уу, машин тоног төхөөрөмжийг сайжруулах ч гэдэг юм уу ийм зүйлүүдийг зайлшгүй хийх шаардлагатай байна.

Өнөөдөр Онцгой байдлын ерөнхий газраас 7 цаг 15 минутад Дорноговь аймгийн Мандах сум руу нисдэг тэрэг гаргаж эрэн хайх үйл ажиллагааг эхлүүлсэн байгаа.

Тийм учраас цаашдаа алслагдсан бүс нутагт, ялангуяа хилийн орчимд гарч

байгаа гэмт хэргийн тоо, хүн алга болгох ч гэдэг юм уу, хил дамнасан худалдаа ч гэдэг юм уу ийм зүйлүүд нэмэгдэх хандлагатай байна.

Тийм учраас бид энэ асуудал дээр тулгуурлаж цаашдаа цагдаагийн байгууллагыг ч гэсэн хүчин чадал, техник хэрэгслийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага бий болж байна л гэж миний хувьд харж байна.

Ингээд энэ асуудлыг баталж өгөх нь зүйтэй. Тэгээд энэ асуудал дээр ч гэсэн манай Онцгой байдлын ерөнхий газар нэлээн санаачилгатай ажиллаж байгаа.

Цаашдаа ч гэсэн бид энэ хүчин чадлаа нэмэгдүүлэх, нисдэг тэргэнийхээ тоог нэмэгдүүлэх, гал унтраах тоног төхөөрөмжөө нэмэгдүүлэх дээр ч гэсэн цаашдаа анхаарах хэрэгтэй. Энэ тал дээр бид дэмжиж ажиллана гэдгээ илэрхийлж байна. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Т.Энхтүвшин гишүүн та ерөнхийдөө дэмжсэн санал хэлж байна. Ингээд М.Оюунчимэг гишүүн асуулт, саналаа хэлье.

М.Оюунчимэг: Т.Энхтүвшин гишүүний хэлж байгаатай санал нэг байна.

Энэ зөвхөн Онцгой байдлын ерөнхий газар гэлтгүй цагдаагийн байгууллага ч гэсэн агаараас ирж хайх нисдэг тэрэг байх нь өөрөө туйлын чухал ач холбогдолтой.

Онцгой байдлын ерөнхий газар 2019 онд аврах нэгж байгуулсан. Үүний ач холбогдол үнэхээр чухал байлаа шүү дээ.

Түүрүүн мэдээлэл өгч байна. 122 хүний амь насыг аварлаа. 850 гаруй хүний аюулгүй байдлыг хангаж

ажилласан гэдэг чинь өөрөө Монгол Улсын хувьд хүний амь нас, иргэдийнхээ эрдэнэт биеийг хамгаална гэдэг нэг номерын асуудал.

Тийм учраас үүнийг илүү чанаржуулах, илүү хүчин чадлыг нь нэмэгдүүлэх асуудал өөрөө чухал байгаа.

Сая хэлж байна. Сүүлийн жилүүдэд гал, усны аюул, байгалийн гамшигт үзэгдлүүд маш их бий болж байна.

Хамгийн сүүлийн үед саяын хэлж байгаа тэр Дорноговь аймагт алга болсон 12 настай охины асуудал хүн бүрийн сэтгэлийг эмзэглүүлж байна.

Энэ нь өөрөө маш цаг алдалгүй, тухайн үед Дорноговь аймгийн цагдаагийн хэлтэс ч юм уу, нэг нисдэг тэрэгтэй байсан бол тэр машины араас хөөж явахаас илүүтэй нисдэг тэргээр хайгаад олсон бол өдийд охиныг олчихсон байгаа болов уу гэж би харамсаж бодож байсан.

Тэгээд Онцгой байдлын ерөнхий газар нисдэг тэрэг энэ эрж хайх ажил гаргасан гэсэн.

Та бүхэнд сүүлийн мэдээлэл байна уу? Энэ охинтой холбоотой асуудлаар.

Яг одоогийн байдлаар тэр нисдэг тэрэг эрж хайгаад цагдаагийн байгууллагуудтай хамтарч та нар ажиллаж байгаа юм байна.

Одоо ямар ч байсан амьд, эрүүл саруул олноосой гэдэг хүсэл хүн бүхэнд байна л даа.

Тэгээд энэ талаар та мэдээлэл байвал өгөөч.

Миний хувьд энэ төслийг бид цаг алдалгүй яаралтай хийж энэ нисдэг тэргийг авах нь зөв өө гэсэн байр суурьтай байна.

Ц.Цэрэнпунцаг: М.Оюунчимэг гишүүн сая асуултад хариулчхаарай.

Ингээд ер нь гишүүд үг, асуулт цуг явж байгаа. Тийм ээ.

Тэгээд дэмжсэн үг хэлчихлээ. Ингээд ажлын хэсгээс ажлын хэсгийн 5 номер хариулъя.

Г.Ариунбуян: Баярлалаа. М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Дорноговь аймгийн Сайншанд суманд 12 настай эмэгтэй хүүхэд сураггүй болсон мэдээллийн дагуу тухайн аймгийн онцгой комисс, цагдаагийн байгууллагаас ажлын хэсэг томилоод эрлийн ажиллагааг зохион байгуулж байна.

Эрлийн ажиллагаанд хүн хүч нэмэгдүүлэх ийм хэрэгцээ шаардлага үүссэнтэй холбогдуулаад уржигдраас эхлүүлээд хүн хүчний тоо нэмэгдсэн.

Өнөөдрийн байдлаар 700 гаруй иргэн, 150 гаруй автомашин хэрэгсэлтэйгээр эрлийн ажиллагааг явуулж байна.

Тэгээд цагдаагийн байгууллагаас өчигдөр орой онцгой байдлын байгууллагад албан ёсоор хүсэлт тавьсны дагуу өнөөдөр өглөө 7 цаг 05 минутад Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр ангийн нисдэг тэргийг Дорноговь аймгийн Мандал сумын нутаг дэвсгэр рүү хөдөлгөөн үйлдүүлсэн.

Эрлийн ажиллагаа одоогоор үргэлжилж байна.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Ундрам гишүүн асуултаа асууя. Үгээ бас хэлье.

Ч.Ундрам: Онцгой байдлын ерөнхий газарт хэрэгжүүлэх гэж байгаа энэ сургалт болон шаардлагатай тоног төхөөрөмж, машин, техник авах төслийг дэмжиж байна.

Бид цаашид онцгой байдал болон цагдаагийнхаа техник, тоног төхөөрөмж. Сая М.Оюунчимэг гишүүн хэлж байна. Нисдэг тэрэг гээд.

Эдгээр тоног төхөөрөмж, машинуудыг яаралтай сайн авч өгч улам хүчин чадлыг нь нэмэх шаардлагатай байна.

Сүүлийн үед гарч байгаа гал, үер, газар хөдлөлтөөс гадна энэ гэмт хэргийн асуудлууд арай дэндүү газар авч байна.

Тэгээд аймаг болон сумын төвүүдийг бид. Ихэнх аймгийн төвүүд эхнээсээ камержуулалт явагдаад эхэлж байгаа.

Бид төсөвт үе шаттай тавиад явж байгаа. Сумын төвүүдийг болон энэ замуудыг ч гэсэн камержуулмаар байгаа юм.

Тэгээд ямарваа нэгэн асуудал гарахад бүгд хараа хяналттай байх шаардлагатай гэж үзэж байна.

Үүнээс гадна Монгол Улсад ер нь ийм асуудал гарахад яг хэдэн нисдэг тэрэг яаралтай бид ашиглах боломж байдаг юм бэ?

Ер нь цаашид хэд хэрэгтэй байдаг юм бэ? Бид ийшээгээ боломжтой бүх л зардал, төсвийг нь ирэх оны төсөвт

тавиад онцгой байдал болон цагдаагийнхаа хүчин чадлыг илүү сайжруулмаар байна. Шаардлагатай тоног төхөөрөмжийг нь авмаар байна.

Тэгэхээр одоо яг хэд нь нисдэг тэрэг байна? Цаашид хэд хэрэгтэй юм бэ гэдэг ийм асуулт байна.

Хоёрдугаарт, Сэлэнгэ аймгийн асуудлыг би Г.Ариунбуян генералд хэд хэдэн удаа асуудал тавьсан байгаа.

Нэгдүгээрт, Алтанбулаг боомт байгуулагдаад ашиглалтад орох гэж байна.

Тэнд маш том барилга байгууламж, лабораториуд баригдана. Тэнд ерөөсөө онцгой байдлын анги, хэлтэс байхгүй.

Өнгөрсөн жил тэнд гал гарахад нэг айл тэр чигээрээ байр, байшин шатаад аймгийн төвөөс гал унтраах машин очсоор байтал байхгүй болсон байгаа.

Тэгэхээр үүнтэй холбоотой нэмэлт тэнд хэсэг нээх шаардлагатай байна.

Мөн Мандал сумын онцгой байдлын орон тоог нэмсэн Засгийн газрын тогтоол гарсан мөртлөө өчнөөн жил тухайн цалинг нь төсөвт ерөөсөө тавьж өгөхгүй.

Тэгээд Мандал сум чинь өөрөө дотроо хоёр тосгонтой. Хэрх, Түнхэл гээд. Түнхэл тосгон нь сумын төвөөс алслагдсан, зам харгуй байхгүй.

Тэнд гал гарахаар сумын төвөөс гал унтраах машин очсоор байтал нөгөө гал нь хамаг айл, амьтан байшин, савыг нь шатаагаад дуусчихдаг.

Үүнтэй адилхан Бугант гээд тосгон байна. Эдгээр газрууд бүгдээрээ ой модтой.

Тэгэхээр энэ асуудлыг 2024 оны төсөвт ер нь суулгасан болов уу? Энэ төслөөр ирж байгаа энэ шинэ машинууд, гал унтраах машинууд чинь ер нь хаашаа хаашаа очих юм бэ? Тэр хуваарилалт нь тодорхой болсон уу, үгүй юу?

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 5 номер. Г.Ариунбуян генерал хариулья.

5 номер Г.Ариунбуян генералын микрофоныг нээе дээ. Ажлын хэсэг дээр 5 номер. Та битгий дараарай.

Г.Ариунбуян: Ч.Ундрам гишүүний асуултад хариулья.

Онцгой байдлын байгууллагад агаараас эрэн хайх, аврах нэгж байгууллагатай холбоотой Франц, Монгол Улсын Засгийн газар хоорондын энэ хэлэлцээрийн хүрээнд 3 нисдэг тэрэг нийлүүлэгдсэн.

Энэ нисдэг тэргийг зөвхөн онцгой байдлын байгууллагын аврах, эрэн хайх, аврах ажиллагаанд ашиглахаас гадна ижил төстэй үүрэг хүлээдэг төрийн бусад байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа.

Өөрөөр хэлэх юм эрүүл мэндийн яаралтай тусламжийн чиглэлээр Эрүүл мэндийн яамтай, байгаль орчныг хамгаалах, тандалт судалгаа хийх чиглэлээр Байгаль орчны яам, цагдаагийн байгууллагад энэ эрлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх гээд энэ салбар дундын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаагаараа энэ нисдэг тэрэг их ач холбогдолтой гэж үзэж байгаа.

Ер нь цаашид нисдэг тэрэгний тоог нэмэгдүүлэх үү гэдэг асуудал дээр нэмэгдүүлэх гэсэн ийм байр суурьтай байгаа.

Өөрөөр хэлэх юм бол энэ нисдэг тэрэг маань өөрийнхөө хурдаар, дундаж хурдаар 680 орчим километр орчим алслалтай, дундаж хурд нь 200 километр цагийн хурдтай нисдэг.

Тийм учраас ер нь Монгол Улсын говь, хээр, хангай, зүүн, баруун гээд өндөр уулархаг газрын энэ бүсчлэлийн байдлаас авч үзээд бүсийн төвүүд дээр энэ нисдэг тэрэгний баазыг өргөтгөх байдлаар байгуулж тухайн нисдэг тэрэгний тоог нэмэгдүүлэх ийм хэрэгцээ шаардлага цаашдаа бий гэдгийг юуны түрүүн онцолж хэлье.

Аймаг, орон нутагт шинээр анги, салбар байгуулах ийм хэрэгцээ шаардлагын талаар Их Хурлын гишүүд, аймаг, орон нутгийн удирдлагаас байнга бидэнд санал хүсэлт тавьж байгаа.

Тухайлбал, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Мандал сум хүн ам суурьшсан их онцлог нутаг.

Мөн бусад аймаг орон нутгаас ч гэсэн энэ талаар эрэн хайх, аврах салбар бүлэг, нэгжийг өргөтгөх асуудлууд тавьж байгаа.

Тэгэхээр энэ асуудлуудыг бид нэгтгээд, судлаад тэгээд Засгийн газрын хуралдаанаар оруулахаар бэлдэж байна. Ирэх оны төсөвт энэ шинэ ангийн зардал, төсөв суугаагүй.

2025 оны төсөвт суулгахаар Засгийн газраар ороод дэмжигдсэн тохиолдолд суулгахаар бид бүхэн ажиллаж байна.

Гал унтраах автомашин төслийн хүрээнд эхний шатны төсөлд 42 нэгж автомашин манайд нийлүүлэгдсэн.

Эдгээр автомашинуудыг аймаг орон нутагт хуваарийн дагуу хуваарилж олгоод гал түймэртэй тэмцэх, гамшиг осолтой тэмцэх үйл ажиллагаанд ашиглагдаж байна.

Өнөөдөр энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой хоёр дахь шатны төсөл хэрэгжвэл нийлүүлэгдэх автомашиныг мөн орон нутагт шилжүүлэх, орон нутгийн иргэдийн аюулгүй байдлыг хангахад ашиглах болно гэдгийг танилцуулъя.

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Ингээд санал хураалтаа явуулъя.

“Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 70.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баагаагийн Батгөмөр танилцуулна.

Хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

Хоёр. “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төсөл

/Засгийн газар 2023.10.04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Ингээд дараагийнхаа асуудалд оръё. Хэлэлцэх асуудал хоёр.

“Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийн хэлэлцүүлгийг явуулъя.

Сая Б.Жавхлан сайд танилцуулгаа хийчихсэн. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэвээрээ байгаа.

Ингээд хэлэлцээрийн төслийн талаар асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Алга байна. Ингээд санал хураалт явуулъя.

“Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын хоорондын

Санхүүгийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 70.0 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр танилцуулна.

Хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

Ингээд Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

Хуралдаан 22 минут үргэлжилж, 10 цаг 19 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД